



КРЕДИТ
ББСБ

ЖИЛИЙН ТАЙЛАН | 2018

АГУУЛГА

Гүйцэтгэх захирлын илгээлт	4
2018 Оны онцлох үйл явдал	7
Компанийн түүх	8
Хувьцаа эзэмшигчид	10
Төлөөлөн удирдах зөвлөл	12
Компанийн бүтэц, зохион байгуулалт	16
Хүний нөөц	17
Технологийн дэвшил	18
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт	20
Технологийн шийдэл	21
Үйл ажиллагаа	24
Санхүүгийн гол үзүүлэлтүүд	25
Санхүүгийн голлох мэдээллүүд	27
Компанийн стратеги	28
Гарах үр дүн	29
Эдийн засгийн орчин	30
Банк бус санхүүгийн байгууллагын зах зээл	32
Хараат бус аудитын тайлан	33



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ИЛГЭЭЛТ

Эрхэм хүндэт харилцагчид, хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагч нараа,

Бидний хувьд 2018 он цаашдын хөгжил дэвшил, өсөлтийнхөө эргэлтийн цэгийг тавьж, үндэс сууриа сайжруулсан жил болон өнгөрлөө. 2018 онд бидний төлөвлөгөөний гол зорилго нь ашигт ажиллагаа болон тоон үзүүлэлтүүд дээр төвлөрөхөөс илүү техник, технологийн шинэчлэлтдээ хөрөнгө оруулж, үндсэн банкны системээ шинэчлэн, компанийн цаашдын хурдацтай өсөх суурийг тавих байсан. Мөн IPO хийж олон нийтийн эзэмшилтэй хувьцаат компани болох зорилгодоо хүрэхэд төвлөрөн ажиллахад оршиж байсан болно.

Банк санхүүгийн компанийн хувьд үндсэн банкны систем (мэдээллийн систем) нь тухайн байгууллагын хамгийн чухал хэсэг байдаг. Системийн аюулгүй байдал, найдвартай ажиллагаа, мэдээллийн автоматжуулалт зэрэг нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаа, цаашлаад компанийн өсөлт болон ашигт ажиллагаанд шууд нөлөөтэй байдаг. Тайлант жилд бид ГрэйпСити Монгол компанийн хөгжүүлсэн Поларис үндсэн банкны системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлээ. Ингэснээр бид бүх төрлийн банкны бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчиддаа санал болгох боломжийг бүрдүүлсэн юм. Түүнчлэн бид МостМони ПСП-тэй хамтран санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх Ард Апп-ийн эхний хувилбарыг зах зээлд амжилттай нэвтрүүлж, Ард Дижитал Банк төсөл дээр ажиллаж эхэлсэн билээ.


Монгол шуудан ХК-тай хамтран олон улсын мөнгөн гуйвуулгын EuroGiro сүлжээнд элсэж мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хийж дуусгалаа. Эхний ээлжинд Солонгос улсын шуудантай хамтын ажиллагааны гэрээ байгуулан 2 улсын хооронд энэхүү үйлчилгээг нэвтрүүлэх төлөвлөгөөтэй байна. Түүнчлэн Монгол Шуудан ХК-ийн салбаруудаар дамжуулан санхүүгийн үйлчилгээгээ хүргэж эхлэх, хөдөө орон нутагт хүрч ажиллах бэлтгэл ажил хангагдсан болно.

Компанийн санхүүжилтын хувьд бид IPO хийх зөвшөөрлөө Монголын Хөрөнгийн Бирж-ээс хүлээн авсан бөгөөд 2019 оны I улиралд багтаан 5.4 тэрбум төгрөг олон нийтээс татан төвлөрүүлэх зорилготой байна. Түүнчлэн тайлан үед Япон улсын Crowdfunder хөрөнгө

оруулалтын сангаас таван сая доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн санхүүжит авах тухай хэлэлцээр хийгдэж дууссан билээ. Компанийн хувьд анх удаагаа том хэмжээний санхүүжилтыг гадны байгууллагаас татаж чадсан бөгөөд энэхүү эх үүсвэрээ 100 хувь компанийн зээлийн багцыг санхүүжүүлэх болно.

2018 онд Ард Кредитын нийт актив 10.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 3 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд оны эцсийн байдлаар зээлийн багц 7.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Мөн 3 тэрбум төгрөгийн итгэлцлийг татан төвлөрүүлж, 342 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Зээлийн багцын чанарын хувьд нийт чанаргүй зээлийн багц 4.1 хувьтай ажилласан байна.

Хүндэтгэсэн,



Чулууны Ганзориг

Гүйцэтгэх захирал

2018 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

- Олон улсын мөнгөн гуйвуулгын EuroGiro систем болон Монгол шуудан ХК-тай хамтран Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг амжилттай эхлүүлэв.
 - Монгол Шуудан ХК-ийн салбаруудаар дамжуулан харилцагчиддаа санхүүгийн үйлчилгээгээ хүргэж эхлэв.
 - Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос IPO хийх зөвшөөрөл аван үнэт цаасаа бүртгүүлэв.
 - Санхүүгийн Зохицуулах Хорооноос цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын тусгай зөвшөөрөл авав.
 - Компанийн ТУЗ нь 2017 оны цэвэр ашгийн 50 хувийг ногдол ашиг хэлбэрээр хуваарилах шийдвэр гаргав.
 - 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 3 тэрбум төгрөгийн итгэлцэл төвлөрүүлэв.
 - Япон улсын Crowdfunder хөрөнгө оруулалтын сангаас 13 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт авах тухай хэлэлцээр хийгдэж 2019 оны I улиралд эхний хэсэг болох санхүүжилтийг татан төвлөрүүлэхээр боллоо.
 - Овердрафтын зээлийн бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлэв.
 - Хүүгүй, барьцаагүй зээлийг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.
 - ББСБ-уудаас салбартаа анхлан хувьцаа барьцаалсан зээлийн бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлэв.
 - ГрэйпСити Монгол компанийн банкны үндсэн систем болох Поларис үндсэн банкны системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэв.
 - Санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх Ард Апп-ийн эхний хувилбарыг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.
 - Ард Санхүүгийн Нэгдлийн санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх салбар Сэнтрал Тауэрт нээгдэж, бид Санхүүгийн Зохицуулах Хорооноос салбарын тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаагаа явуулж эхлэв.
-

КОМПАНИЙН ТҮҮХ

Ард Кредит нь санхүүгийн салбарт дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, зах зээлд манлайлан ажиллах зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж буй Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хөрөнгө оруулалттай Монгол Улсын тэргүүлэх банк бус санхүүгийн байгууллагын нэг юм.

2011

Интергрупп Интернэшнл ХХК-ийн хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулагдав.

2013

Ард Санхүүгийн Нэгдлийн ХК хөрөнгө оруулалт хийн шинэ удирдлага, стратегитэйгээр ажиллаж эхлэв.

2014

СЗХ-ны зөвшөөрлөөр анхны хаалттай өрийн бичгээ амжилттай гаргаж нийт 550 сая төгрөгийн санхүүжилт босгов.

Хувьцаа эзэмшигчиддээ анхны ногдол ашиг хуваарилав.

Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагааны чиглэлээ өргөжүүлэв

Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан-тай хамтран ажиллаж, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой айл өрхүүдэд хөнгөлөлттэй зээл олгож эхлэв.

Анхны хаалттай өрийн бичгээ гаргав.

2015

Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж, Ард Санхүүгийн Нэгдэл нь компанийн 58 хувийг эзэмших болов.

Бичил Санхүүгийн Хөгжлийн Сангаас хөнгөлөлттэй санхүүжилт авч, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зээл олгож эхлэв.

Хөдөөгийн бичил санхүүгийн байгууллагуудад бөөний зээл олгож эхлэв.

2016

Хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа эрхлэх төрөлд хамрагдах ББСБ болов. СЗХ-ны шинэ журмын дагуу Хөрөнгө удирдлагын үйл ажиллагаа эрхлэх төрөлд хамрагдах ББСБ болов.

Ард Санхүүгийн Нэгдэлтэй хамтран Хөрөнгө Оруулагч Үндэстэн Чуулга Уулзалтыг зохион байгуулж үндэсний хөрөнгө оруулагчдын хөдөлгөөнийг эхлүүлэв.

Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж, Ард Санхүүгийн Нэгдэл нь компанийн 80.7 хувийг эзэмших болов.

Хувь нийлүүлсэн хөрөнгөө 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн СЗХ-ны шалгуур үзүүлэлтийг ханган ажиллалаа.

2017

ББСБ-уудаас салбартаа анхлан Кредит картын бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлэв.

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудаас салбартаа хамгийн бага зээлийн хүүтэй байгууллага болон ажиллаж эхэлсэн.

ГрэйпСити ХХК-тай стратегийн түвшинд хамтран ажиллахаар болж, Поларис үндсэн банкны систем болон Мостмони үйлчилгээг нэвтрүүлэх гэрээ байгууллаа.

2017 оны зургадугаар сарын 22-нд СЗХ-ноос Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллав.

Хаалттай хүрээнд компанийн бонд гаргаж хөрөнгийн зах зээл дээрээс 1.7 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлэв.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Ард Кредит ББСБ нь 2018 оны байдлаар нийт 3 хувьцаа эзэмшигчтэйгээр ажиллаж байна.



“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК

Ард Кредитын хувьцааны дийлэнх буюу 80.7 хувийг эзэмшигч “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь 2005 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад хөрөнгө оруулалт хийж, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар өөрийн хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг өсгөх зорилт тавин ажиллаж байгаа үндэсний санхүүгийн холдинг компани юм. Компани нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш санхүүгийн салбарт хөрөнгө оруулалт хийж, хөрөнгө оруулалт хийсэн компаниудаа амжилттай удирдан, зохион байгуулж байна.

С.Гэрэлтуяа

С.Гэрэлтуяа нь 1998 онд МУИС-ийг олон улсын харилцаа, аялал жуулчлалын бакалавр зэрэгтэй төгссөн. 2000-2003 оны хооронд “МИАТ” ХК-ийн төлөөлөгчөөр БНХАУ-ын Бээжин хотод ажиллаж байсан бөгөөд 2003 оноос хойш “Мон-Интернэшнл” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. С.Гэрэлтуяа нь Ард Кредит ББСБ-ын 12.7 хувийн хувьцааг эзэмшдэг бөгөөд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн болно.

В.Баяржаргал

В.Баяржаргал нь 2006 онд Техникийн Их Сургуулийг бизнес менежментийн чиглэлээр төгссөн. 2006 онд “М-Си-Эс Электроникс” ХХК-аас ажлын гараагаа эхэлсэн бөгөөд 2012 оноос “Прогресс Транс” ХХК болон “Интергрупп Интернейшнл” ХХК-ийн үйл ажиллагаа эрхэлсэн захирлаар тус тус ажиллаж байна. В.Баяржаргал нь Ард Кредитын 6.6 хувийн хувьцааг эзэмшдэг бөгөөд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтыг хамгаалах, компанид үр ашигтай шийдвэр гаргах, компанийн бодлого, стратегийг тодорхойлох зэрэг чухал шийдвэрүүдийг гаргаж ажилладаг тул мэргэжлийн, чадварлаг, туршлагатай ТУЗ-ийн гишүүдийг сонгох нь маш чухал байдаг. Одоогоор Ард Кредит ББСБ-ын ТУЗ нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүд нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах өндөр хариуцлага хүлээдэг. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд банк, эдийн засаг, бизнесийн менежмент, олон улсын харилцааны чиглэлээр мэргэшсэн, тус бүрийн чиглэлээр компани болон ТУЗ-ийн үйл ажиллагаанд бодит хувь нэмэр оруулж чадах хүмүүс багтсан болно.



Чулууны Ганхуяг

ТУЗ-ийн дарга

Мэргэжил: Эдийн засагч, банк санхүүгийн менежмент
Давхар албан тушаал: “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн гүйцэтгэх захирал

Монголын Хөрөнгийн Биржээс 1991 онд хөдөлмөрийн гараагаа эхэлсэн тэрбээр 1997 онд Унгар Улсын Будапешт хотын Корвинус Их Сургуулийг дүүргэж, Монголбанкинд хянан шалгагчаар оржээ. 2001 онд Хас Банкныг үүсгэн байгуулж, гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаад, 2010-2012 онд Монгол Улсын Сангийн Дэд Сайдын албанд томилогдон ажиллаж байв. Тэрээр Унгар Улсын өргөмжит консул, Монголын Эдийн Засгийн Форумын санаачлагч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Монголын Оюутны Холбооны Ерөнхийлөгч, Олон Улсын Бичил Санхүүгийн Төвийн УЗ-ийн гишүүн, Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны Ерөнхийлөгч зэрэг албан тушаал хашиж байснаас гадна түүнийг 2009 онд Дэлхийн Эдийн Засгийн Форумаас Дэлхийн Залуу Манлайлагчаар өргөмжлөгдсөн байна.



Майнбаярын Тулгат

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Мэргэжил: Эдийн засагч

Давхар албан тушаал: "Хишиг Арвин" ХХК-ийн дэд захирал

М.Тулгат нь 2003 онд Япон Улсын Киото Их Сургуулийг эдийн засгийн ухааны бакалавр зэрэгтэй, 2005 онд Япон Улсын Киото Их Сургуулийг эдийн засгийн ухааны магистр зэрэгтэй төгссөн. Тэрээр Софтбанк Групп-д бизнес төлөвлөгч, "Бэкферст" ХХК-д захирлын албан тушаал хашиж байсан. 2013 оноос одоог хүртэл "Хишиг Арвин Индастриал" ХХК-д дэд захирлаар ажиллаж байна.



Ванчигийн Ганзориг

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Мэргэжил: Бизнес удирдлага

Давхар албан тушаал: "BSP" ХХК-ийн ТУЗ-ийн дарга

В.Ганзориг нь 2005 онд Австрали Улсын Норте Дем Их Сургуульд МВА зэрэг, 2010 онд Япон Улсын IUS сургуулийг цахим бизнесийн мастер зэрэгтэйгээр суралцаж төгссөн бөгөөд АНУ (Yale), Англи (Oxford), Өмнөд Африк (WITS) улсуудад удирдлага, манлайлал, өөрчлөлтийн менежмент чиглэлээр мэргэжлийн сургалтуудад хамрагдсан байна. Тэрээр МУИС-ийн Худалдааны Сургууль, Худалдаа Хөгжлийн Банк, ХасБанк, Шунхлай Группийн удирдлагын багт ажиллаж байсан ба сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээлэл, олон нийтийн харилцааны чиглэлээр ажилладаг Медиа Групп ба Бат Солюшн Партнерс компаниудад удирдах албан тушаал хашиж байсан туршлагатай.



Чулууны Ганзориг

ТУЗ-ийн ердийн гишүүн, гүйцэтгэх захирал

Мэргэжил: Бизнес менежмент

Ч.Ганзориг нь 2007 онд Шанхайн Их Сургуулийг Хятад хэл, 2010 онд Унгар Улсын Корвинусын Их Сургуулийг бизнес менежментийн чиглэлээр бакалавр зэрэгтэйгээр суралцаж төгссөн. Ч.Ганзориг нь одоогийн Ард Секюритиз ҮЦК-д хөрөнгө оруулалтын шинжээч, Ард Санхүүгийн Нэгдэлд Хөрөнгө оруулалтын мэргэжилтнээр ажиллаж байсан туршлагатай. 2013 оноос одоог хүртэл Ард Кредитын гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Мөн тэрээр Ард Секюритиз ҮЦК, Вайлд Дижитал Аженси болон Дуулиан 2020 ТББ зэрэг байгууллагуудын ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг.



Сэдбазарын Гэрэлтуяа

ТУЗ-ийн ердийн гишүүн

Мэргэжил: Олон улсын харилцаа, аялал жуулчлал
Давхар албан тушаал: "Мон-Интернэйшнл" ХХК-ийн гүйцэтгэх захирал

С.Гэрэлтуяа нь 1998 онд МУИС-ийг олон улсын харилцаа, аялал жуулчлалын бакалавр зэрэгтэй төгссөн. Тэрээр "МИАТ" ХК-ийн төлөөлөгчөөр БНХАУ-ын Бээжин хотод ажиллаж байсан бөгөөд 2003 оноос хойш "Мон-Интернэйшнл" ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. С.Гэрэлтуяа нь Ард Кредитын 12.7 хувийн хувьцааг эзэмшдэг бөгөөд ТУЗ-ийн гишүүн болно.



Барамсайн Ганбат

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Мэргэжил: Эдийн засаг

Давхар албан тушаал: Техник Технологийн Дээд
Сургуулийн гүйцэтгэх захирал

Б.Ганбат нь 1998 онд МУИС-ийг эдийн засагч мэргэжлээр, 2011 онд СЭЗДС-ийг санхүүгийн менежмент мэргэжлээр магистр зэрэгтэй суралцаж төгссөн. ХасБанкинд үйл ажиллагааны хэлтсийн дарга, үйл ажиллагаа эрхэлсэн захирал, "И Ай Ти" ХХК-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан бөгөөд одоо Техник Технологийн Дээд Сургуулийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



Ванданцэрэнийн Баяржаргал

ТУЗ-ийн ердийн гишүүн


Мэргэжил: Бизнесийн менежмент

Давхар албан тушаал: "Интергрупп Интернэйшнл"
ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирал

В.Баяржаргал нь 2006 онд Техникийн Их Сургуулийг бизнес, менежментийн чиглэлээр төгссөн. 2006 онд "М Си Эс Электроникс" ХХК-аас ажлын гараагаа эхэлсэн бөгөөд 2012 оноос "Прогресс Транс" ХХК болон "Интергрупп Интернэйшнл" ХХК-ийн үйл ажиллагаа эрхэлсэн захирлаар тус тус ажиллаж байна. В.Баяржаргал нь Ард Кредитын 6.6 хувийн хувьцааг эзэмшдэг бөгөөд ТУЗ-ийн гишүүн болно.

КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Ард Кредит нь олон улсын жишигт нийцэхүйц компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэн Монгол Улсын банк бус санхүүгийн салбарт жишиг байгууллага болон ажиллаж байна. Компанийн засаглалын үр дүнг нэмэгдүүлэх суурь нөхцөл нь ТУЗ-ийн дэргэдэх хороод байдаг бөгөөд хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргаж ажилладаг.




ХҮНИЙ НӨӨЦ

Ард Кредитын үйл ажиллагааны бүтэц, хүний нөөц нь голлон компанийн үндсэн чиглэл болох зээлийн үйл ажиллагаа дээр төвлөрдөг бөгөөд бусад функцууд болох маркетинг, мэдээллийн технологи, дотоод аудит зэргийг толгой компаниас менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээгээр авдаг болно. Ингэснээр үндсэн үйл ажиллагаан дээрээ төвлөрч, бага зардлаар ажиллах бололцоотой байдаг. 2018 онд бид нийт 21 ажилтантайгаар, 4 хэлтэст хуваагдан үйл ажиллагаа явууллаа.




ТЕХНОЛОГИЙН
ДЭВШИЛ

E V O L U T I O N O F
TECHN



OLOGY

2018




БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

Ард Кредит нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн үйлчлүүлэгчдийнхээ эрэлт хэрэгцээнд тулгуурлан санхүүгийн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд байнга нэвтрүүлж ирсэн. Үүний нэг тод жишээ бол 2018 оны хоёрдугаар улиралд Ард Апп гар утасны аппликэйшныг зах зээлд нэвтрүүлсэн явдал юм. Энэхүү аппликэйшныг хүмүүс утсандаа татаж, суулгаснаар Ард Кредитээс үзүүлж буй данс нээлгэх, бэлэн мөнгө авах, мөнгө шилжүүлэх, төлбөр төлөх, зээл авах зэрэг үйлчилгээнүүдийг авах боломжтой юм.

2018

2019

Өөрийн биеэр ирж бүртгүүлэх		Утсаар өөрөө бүртгүүлэх
4 хуудас зээлийн өргөдөл бөглөх		Цахим зээлийн хүсэлт илгээх
5 өдөрт зээлийн шийдвэр гарах		Харилцагчийн зээлжих эрхийг хиймэл оюун ухаан тооцож 5 минутад шийдвэрлэнэ.
Барьцаа хөрөнгөтэй байх		Барьцаа хөрөнгө шаардлагагүй
		Бусад санхүүгийн үйлчилгээ

Ард Аппыг ашигласнаар хүмүүс өөрийн биеэр санхүүгийн байгууллага дээр очиж анкет бөглөх, зээлийн өргөдөл бөглөх, зээлийн хорооны хурлаар орох зэрэг олон төрлийн шат дамжлага дамжин цаг хугацаа алдах шаардлагагүй болно.

ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ

Ард Кредит нь Ард Аппыг банкны программ хангамж, төлбөр тооцооны системээр мэргэшсэн туршлагатай "Грэйпсити Монголиа" ХХК болон "Мост ПСП" ХХК-тай хамтран харилцагчдад хүргэж байна. Ард Апп нь Монгол Улсын үндэсний хэмжээний цахим төлбөр тооцооны систем болох Мост Мони систем болон Мост Скор системийн дэд бүтэц дээр суурилан ажиллах юм.



Биометрик



Үүлэн систем



Хиймэл оюун ухаан

Мост Скор систем нь зээл хүсэгчийн мэдээлэл, ХУР систем дээр үндэслэн тусгай алгоритмаар кредит оношлогоог автоматаар хийж санхүүгийн байгууллагад илгээж, онлайн зээлийн санал авна. Зээлдэгч зээлийн саналуудаас сонгож зээл авна.

ХАРИЛЦАГЧ ӨӨРИЙГӨӨ БҮРТГЭХ

Та салбар дээр ирэлгүйгээр хиймэл оюун дээр тулгуурласан технологийн тусламжтайгаар гар утсаараа манай харилцагч болох боломжтой.

ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


Та хаанаас ч, хэзээ ч гар утсаараа дамжуулан 2 сая хүртэлх төгрөгийн БАРЬЦААГҮЙ зээлийг 3 минутад авах боломжтой боллоо.


ХУВЬЦАА

Та онлайнаар үнэт цаасны дансаа удирдаж, арилжаанд оролцох боломжтой.

ХУРИМТЛАЛ

Өндөр өгөөж бүхий хуримтлалын дансаа банкинд очилгүйгээр нээх боломжтой.





АРД ШОП

Бүх төрлийн бараа бүтээгдэхүүнийг хамгийн хялбараар захиалан хүргүүлж авах боломжтой онлайн дэлгүүр.

ЛОЯЛТИ

Та манай бүх охин болон хараат компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээ авсан тохиолдолд танд олгогдох урамшуулал оноо юм.

БЛОКЧЭЙН ТЕХНОЛОГИ

Монголын анхны цахим арилжааны бирж болох Trade.mn дээрх крипто валютын дансаа удирдах боломжтой.

QPAУ ҮЙЛЧИЛГЭЭ

QR код ашиглан төлбөр төлөх, нэхэмжлэл үүсгэх болон өөрийн дансандаа ОРЛОГО хүлээн авах QR код үүсгэх боломжтой.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ард Кредит нь зээл олгох, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, итгэлцэл татах зэрэг 7 төрлийн санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг. Компани нь үйл ажиллагаагаа Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд явуулдаг болно.

2018 онд 407 иргэн, Аж ахуй нэгжид нийт 10.8 тэрбум төгрөгийн цэвэр зээл олгож, зээлийн багц 7.6 тэрбум төгрөгт, зээлдэгчийн тоо 947-д тус тус хүрсэн байна.

Идэвхтэй зээлийн тоо 58 хувиар өсч, зээлийн дундаж хэмжээ 8 сая төгрөг болж буурсан байна.

Нийт цэвэр зээлийн хэмжээ

2016	=====	4,868,055.00
2017	=====	7,796,092.00
2018	=====	7,545,803.00

Харилцагчийн тоо

2015	=====	438
2016	=====	382
2017	=====	598
2018	=====	947

Зээлийн сарын жигнэсэн дундаж хүү өмнөх оноос 0.14 хувиар буурч, 2.2 хувьд хүрсэн нь ББСБ-ын салбарын дундаж хүүтэй харьцуулахад 1.1 нэгжээр бага, банкны салбартай харьцуулахад 0.8 нэгжээр өндөр байна.

Тайлант хугацаанд нийт олгосон зээлийн 56.1 хувийг бичил болон жижиг дунд бизнесийн зээлийн зориулалтаар, 20.4 хувийг хэрэглээний зээлд тус тус олгосон байна.

2018 онд 1-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн эрсдэлтэй зээлийн нийт багцад эзлэх хувь 4.19 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. ББСБ-ын салбарын чанаргүй зээлийн үзүүлэлттэй харьцуулахад 5.3 хувиар бага байна.

САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД




Нийт хөрөнгийн дүн өнгөрөгч оноос 275.4 сая төгрөгөөр өсч, тайлант онд 10.4 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт хөрөнгийн 90 гаруй хувийг хөрвөх чадвартай мөнгөн хөрөнгө буюу эргэлтийн хөрөнгө эзэлж байна.

2018 онд 7.5 тэрбум төгрөгийн зээлийн багцыг бүрдүүлэн өмнөх оны түвшинд барьж ажиллалаа. Төлбөрийн чадварт онцгой анхааран, чанартай зээлийн багцыг бүрдүүлсэн.

Нийт хөрөнгө /цэвэр зээлийн хэмжээ/ (төг)




2016	Нийт хөрөнгө		5,692,661.00
	Нийт цэвэр зээлийн хэмжээ		4,868,065.00
2017	Нийт хөрөнгө		10,196,336.00
	Нийт цэвэр зээлийн хэмжээ		7,796,092.00
2018	Нийт хөрөнгө		10,471,767.40
	Нийт цэвэр зээлийн хэмжээ		7,545,803.00

Нийт хөрөнгөд эзлэх зээлийн багц

2016		85.50%
2017		76.50%
2018		89%

Өөрийн хөрөнгийн хэмжээ тайлант онд 3.7 тэрбум төгрөгт хүрсэн. Санхүүгийн зохицуулах хорооны өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан.

Нийт өөрийн хөрөнгө (төг)

2016		3,293,581.00
2017		3,735,338.00
2018		3,757,383.50

Нийт орлого

Хүү болон түүнтэй адилтгах орлого	=====	1,788,320.30
Гадаад валют арилжааны орлого	-	1,542.30
Үнэт цаасны арилжааны орлого	=====	208,404.70
Үйлчилгээний орлого	=====	114,762.50
Үнлсэн бус үйл ажиллагааны орлого	=====	235,282.80

Хүү болон түүнтэй адилтгах орлого

2016	=====	1,363,843.6
2017	=====	1,766,868.8
2018	=====	1,788,320.3

Ард Кредит нь зээл олгох, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, итгэлцэл татах зэрэг 7 төрлийн санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг. Компани нь үйл ажиллагаагаа Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд явуулдаг болно

Цэвэр ашиг

2016	=====	401,764.0
2017	=====	641,757.0
2018	=====	342,045.9

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ МЭДЭЭЛЛҮҮД

2018 онд 1.7 тэрбум төгрөгийн хүүгийн орлоготой, 342 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 275 сая төгрөгөөр өсч, 10.5 тэрбум төгрөгт хүрч, үүнээс 7.5 тэрбум төгрөгийн зээлийн багц бүрдүүлж байна. Хүүгийн орлого болон бусад үйл ажиллагааны орлого өндөр байгаа хэдий ч цэвэр ашиг буурсанд үйл ажиллагааны зардал голлох нөлөөтэй байсан.

2018 онд манай компани дижитал банк болох үйл ажиллагааны хүрээнд хэд хэдэн үе шатат арга хэмжээнүүдийг авч эхлүүлсэн. Үүнтэй холбоотойгоор ашигт ажиллагаанд анхаарах бус бэлтгэл ажилд төвлөрөн ажилласан юм. Бид үндсэн банкны үйлчилгээг нэвтрүүлэн, мэдээллийн бааз бий болгох ажлыг эхлүүлэн өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Тус онд банк болон бусад дотоодын санхүүгийн байгууллагаас зээл аваагүй бөгөөд өмнөх онуудад авсан банк болон бусад санхүүгийн байгууллага дахь зээлийн үлдэгдлийг хугацаанд нь тогтмол төлж байна.

2015, 2016, 2017 онуудад цэвэр ашгийн 50 хувиар ногдол ашгийг тогтмол хуваарилсаар ирсэн байна. 2018 оны байдлаар ТУЗ-ийн ээлжит хурлын шийдвэр хараахан гараагүй болно.

Тайлант хугацаанд Монголын хөрөнгийн биржээс зөвшөөрөл олгогдон хөрөнгийн зах зээл дээр хувьцаат компани болон гарах төлөвлөгөөтэй байсан боловч нэг тайлант үеэр ухарсан.

2018 оны туршид Ард Кредит өөрийн хөрөнгийн хүрэлцээ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа зэрэг үзүүлэлтүүдийг тогтоосон хэмжээнд биелүүлэн ажилласан.

		2016	2017	2018
Төлбөр түргэн гүйцэтгэх харьцаа	8%-иас дээш	9.7%	22.3%	18.1%
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15%-иас хэтрэхгүй	4.2%	2.3%	2.1%
Чанаргүй зээлийн хувь	5%-иас хэтрэхгүй	6.9%	5.5%	4.2%
Өр хөрөнгийн харьцаа		42.1%	63.3%	64.1%

КОМПАНИЙН СТРАТЕГИ

Ард Кредит нь уламжлалт үйл ажиллагааны арга барилаас финтек бизнесийн загвар руу эргэлт буцалтгүй шилжээд байна. Ингэснээр харилцагчид дэлхийн хаанаас ч өөрийн санхүүгээ хүссэн цагтаа удирдах боломжтой юм. Энэхүү зорилгын хүрээнд Ард Кредит нь дараагийн 5 жилд хоорондоо харилцан хамаарал бүхий доорх зорилт, стратегийг дэвшүүлэн ажиллаж байна:



Финтек санхүүгийн байгууллага болох

Үйл ажиллагаагаа зогсолтгүй хурдтай өргөжүүлэх

Харилцагч төвтэй, шинэлэг санхүүгийн үйлчилгээг тогтмол нэвтрүүлэх

Байгал орчинд ээлтэй үйл ажиллагаа бүхий нийгмийн хариуцлагыг

хэрэгжүүлэгч байгууллага болох

ГАРАХ ҮР ДҮН

Ард Кредит нь орчин үеийн санхүүгийн дэвшилтэд технологи дээр суурилсан, хамтран ажиллагч байгууллагуудын дэд бүтцийг ашиглан Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжүүдэд хэрэглээний болон жижиг дунд бизнесийн зээлийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх юм. Энэхүү зорилгынхоо хүрээнд компани нь Ард Апп-д суурилсан санхүүгийн цогц үйлчилгээ харилцагчдаа хүргэхээр төлөвлөөд байна.

73.7

51,602 харилцагчтай болж,
2017 оноос 73.7 дахин өснө.

8.4

Нийт зээл 75.2 тэр.төг-т хүрч,
2017 оноос 8.4 дахин өснө.

1.56%

Зээлийн сарын хүү 1.56%-3.0%
болж буурна.

87.9%

Нийт харилцагчийн 87.9% буюу 45,362
нь Ард Аппликэйшин хэрэглэнэ.

65%

Зээлийн багцын 35% бизнесийн зээл,
65% хэрэглээний зээл байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2018 онд Монгол улсын эдийн засаг 6.9%-иар өсч, өмнөх оноос 1.8 хувиар өссөн байна. Энэ үзүүлэлт нь сүүлийн 4 жилийн хугацаанд хамгийн өндөр хувиар өссөн үзүүлэлт юм. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдсэн, өрхийн зээлийн олголт ихэссэнтэй холбоотой.

Бүтээгдэхүүний цэвэр татвар 20.1%-иар, боловсруулах үйлдвэрлэл 15.7%-иар, санхүү болон даатгалын үйл ажиллагаа 12.3%-иар тус тус өссөн. Мөн үргэлжилсэн уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, өрхийн зээлийн олголт нэмэгдсэн зэрэг нь эдийн засгийн өсөлтөд ихээхэн нөлөөлсөн. Харин ипотекийн зээлийн олголт буурсантай холбогдуулан барилга болон бусад үйлчилгээний ажиллагаа 5 хүртэл хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн улсын нэгдсэн төсвийн тэнцэл сүүлийн 8 жилийн хугацаанд анх удаа ашигтай гарсан байна.

Монгол төгрөгийн гадаад валюттай харилцах ханш Монгол банкны нэрлэсэн ханш дунджаар 1 ам доллар 2633.37 төгрөг, 1 евро 2988.53 төгрөгөөр тус тус тогтоогдсон байна. 2018 оны 2-р улиралд Монгол банкнаас урьдчилсан гүйцэтгэлээр мөнгөний нийлүүлэлт 15.9 их наяд төгрөг хийгдэж, өмнөх оны мөн үеэс 22.8 хувиар өссөн. Нийт хадгаламжийн хэмжээ 13.2 төгрөг байгаагаас 77 хувийг төгрөгийн хадгаламж эзэлж байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оноос 26.5 хувиар өссөнөөр 17.2 их наяд төгрөг болсон. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

2018 үнэт цаасны зах зээлийн хувьд өндөр өсөлттэй байж, олон дээд амжилтуудыг шинэчлэн тогтоож үнэт цаасны арилжаагаар 360.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 667.3 сая ширхэг үнэт цаас арилжсан байна. Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2.5 их наяд болж, ТОП-20 дундаж индекс 20076.5 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 2032 нэгжээр буурсан байна.

Гадаад худалдааны тэнцэл 2018 онд 27.5 сая америк долларын ашигтай гарчээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд 0.6 хувиар өсч, өмнөх оны жилийн эцсээс 8.1 хувиар өссөн байна. Орон сууцны үнийн индекс өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2018 онд Монгол улсын хувьд макро эдийн засгийн орчин тогтворжин, зээлжих зэрэглэл дээшилж, банкны зээлийн хүү 17.6 хувьд хүрч бууран, ажилгүйдлийн түвшин сүүлийн 3 жилийн хугацаанд хамгийн бага түвшинд хүрсэн зэрэг сайн үзүүлэлттэй жил болж өнгөрөв.

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн Зохицуулах хороо

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛ

2018 оны II улирлын байдлаар Монгол Улсад 539 банк бус санхүүгийн байгууллага 1.4 сая харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлж байна. Банк бус санхүүгийн байгууллагын тоо 2013 оноос хойш огцом нэмэгдэж эхэлсэн боловч сүүлийн жилүүдэд өсөлт нь харьцангуй саарах хандлагатай байна. Энэ нь СЗХ-оос ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргасантай холбоотой юм.

ББСБ-ын тоо

2018 II улирал	539
2017	534
2016	518
2015	450

Харилцагчийн тоо

2018 II улирал	1,423,597
2017	1,471,099
2016	592,461
2015	636,341

2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 869.2 тэрбум төгрөгийн зээлийн багц, 1.3 их наяд төгрөгийн нийт хөрөнгөд хүрч ажилласан байна. Активын хэмжээ өмнөх оноос 32 хувиар өсөхөд цэвэр зээлийн үлдэгдэл болон мөнгөн хөрөнгийн өсөлт онцгой түлхэц болсон юм.

ББСБ-ын пассивын бүтцийн хувьд өмнөх оноос 30 хувийн өсөлттэй гарсан баөгөөд үүний шалтгаан нь итгэлцлийн хэмжээ нэмэгдсэн, 2017 оны 27 дугаар хэрэгжилтийн дагуу хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлсэн.

Ашиг ажиллагааны хувьд ББСБ-ууд 259.5 тэрбум төгрөгийн орлого олж, 101.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн Зохицуулах хороо

ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН

“АРД КРЕДИТ ББСБ” ХХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санал дүгнэлт

Бид 2018 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Ард Кредит ББСБ” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Ард Кредит ББСБ” ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлтийн үндэслэл гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байдаг. Гэхдээ бид энэхүү асуудалд ямар нэг баталгаа илэрхийлэхгүй болно. 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар доорх асуудлыг аудитын гол асуудал болгон оруулсан.

1.Тайлангийн хугацаанд шинээр хувьцаа гаргаж (Initial Public Offering хийх) олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгох, дүрмийн сангийн 25 хувьтай тэнцэх 70 сая ширхэг хувьцаа шинээр гаргаж олон нийтэд худалдаалах ажлуудыг зохион байгуулж эхэлсэн.

Компани өөрчлөн зохион байгуулах үйл ажиллагааг компанийн тухай хуулийн дагуу зохион байгуулж эрх бүхий байгууллагуудад хүсэлтээ гаргаснаар Монголын Хөрөнгийн Биржийн гүйцэтгэх захирлын 2018 оны 11 сарын 30-ны өдрийн А/133 дугаар тушаал, Монгол улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 03 дугаар тогтоолоор тус тус хувьцаа гаргах үйл ажиллагааг зөвшөөрч үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг эрх бүхий байгууллагуудад зөвшөөрсөн.

Аудитаар IPO хийхтэй холбоотой хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр, Монголын Хөрөнгийн Бирж болон Санхүүгийн Зохицуулах хороо зэрэг эрх бүхий байгууллагуудын шийдвэртэй танилцсан.

2.Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 2018/1 тоот тогтоолоор 787,500.0 мянган төгрөгийн нэмж төлөгдсөн капиталаар дүрмийн санг нэмэгдүүлж нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 100,000 төгрөг байсныг 160,000 төгрөг болгон өөрчилсөн. Ингэснээр хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь, хувьцааны тоо хэмжээнд ямар нэг өөрчлөлт ороогүй.

Мөн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 2018/2 тоот тогтоолоор нэгж хувьцааны үнэ 160,000 төгрөг байсныг 10 төгрөг болгож 16,000 дахин бууруулж, тоо ширхгийг 16,000 дахин өсгөж энгийн хувьцааны жижигрүүлэлт хийсэн. Аудитаар хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай танилцаж хувьцааны жижигрүүлэлтийн тооцооллыг давтан гүйцэтгэсэн.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайланд тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.

- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бусад

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчид зориулан бэлтгэсэн ба бид тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



**2019 ОНЫ 02 ДУГААР
САРЫН 18-НЫ ӨДӨР**

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодруулга	2018.12.31. мянган төгрөг	2017.12.31. мянган төгрөг
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгөн хөрөнгө	6.1.	1,123,728.8	1,095,274.2
Зээл, зээлийн хүүний авлага /цэвэр/	6.2.	7,545,803.0	8,023,702.5
Богино хугацаат хөрөнгө оруулалт	6.3.-6.4.	671,276.9	28,000.0
Бусад санхүүгийн хөрөнгө	6.5.	730,401.9	495,050.2
Бусад хөрөнгө	6.10.-6.11.	184,297.7	312,019.9
Эргэлтийн хөрөнгийн дүн		10,255,508.2	9,954,046.8
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө (цэвэр)	6.12.	168,974.3	237,845.5
Биет бус хөрөнгө (цэвэр)	6.13.	47,284.8	1,443.3
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө			
Хойшлогдсон татварын хөрөнгө			
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		216,259.1	239,288.8
НИЙТ ХӨРӨНГӨ		10,471,767.3	10,193,335.6
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Бусдаас авсан зээл	6.6.	554,605.8	1,068,255.6
Бусад эх үүсвэр	6.7.	4,970,575.2	4,402,298.8
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	6.8.	259,508.9	352,465.4
Бусад санхүүгийн өр төлбөр	6.9.	198,366.1	22,204.9
Татвар шимтгэлийн өглөг	6.14.	66,016.2	55,873.2
Богино хугацаат өр төлбөрийн дүн		6,049,072.3	5,901,097.9
Урт хугацаат өр төлбөр			
Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл	6.9.	661,292.8	552,881.4
Хойшлогдсон татварын өглөг	6.14.	4,018.8	4,018.8
Урт хугацаат өр төлбөрийн дүн		665,311.5	556,900.2
Нийт өр төлбөр		6,714,383.8	6,457,998.1
Өөрийн хөрөнгө			
Энгийн хувьцаа	6.15.	2,100,000.0	1,312,500.0
Нэмж төлөгдсөн капитал	6.15.		787,500.0
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	6.15.	1,657,383.5	1,635,337.5
Нийт өөрийн хөрөнгө		3,757,383.5	3,735,337.5
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		10,471,767.3	10,193,335.6

**ОРЛОГО ҮР ДҮН БОЛОН
БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

	Тодруулга	2018.12.31. мянган төгрөг	2017.12.31. мянган төгрөг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	6.16.	1,788,320.3	1,766,868.6
Хүү түүнтэй адилтгах зардал	6.17.	(914,631.4)	(656,439.6)
Цэвэр хүүний орлого		873,688.9	1,110,429.0
Гадаад валют арилжааны орлого	6.23.	1,542.0	908.5
Үнэт цаасны арилжааны орлого	6.23.	208,404.7	
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн олз	6.23.	9,950.1	87,807.0
Үнэт цаасны үнэлгээний олз	6.23.	108,708.2	
Үйлчилгээний орлого	6.18.	114,762.3	91,190.5
Гадаад валют арилжааны зардал	6.23.	(10,507.4)	(1,864.0)
Үнэт цаасны арилжааны алдагдал	6.23.	(5,819.7)	
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн гарз	6.23.	(25,980.8)	(85,347.8)
Үнэт цаасны ханшийн тэгшитгэлийн гарз	6.23.		
Боловсон хүчинтэй холбоотой зардал	6.19.	(357,348.1)	(310,032.9)
Үйл ажиллагааны бусад зардал	6.20.	(548,799.3)	(400,430.6)
Үйл ажиллагааны ашиг		368,600.8	492,659.7
Эрсдэлийн сангийн зардал	6.21.	(131,274.1)	(140,590.8)
Үндсэн үйл ажиллагааны ашиг, алдагдал		237,326.8	352,068.9
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	6.22.	235,282.8	393,307.3
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	6.22.	(81,344.8)	(31,431.8)
Татварын өмнөх ашиг (алдагдал)		391,264.8	713,944.4
Орлогын албан татварын зардал	6.24.	(49,218.9)	(72,187.7)
Тайлант жилийн татварын дараах ашиг		342,045.9	641,756.7
Бусад дэлгэрэнгүй орлого:			
Эрсдэлийн сангийн нөөцийн өсөлт, (бууралт)			
Нийт дэлгэрэнгүй орлого		342,045.9	641,756.7

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Хувьцаат капитал мянган төгрөг	Нэмж төлөгдсөн капитал мянган төгрөг	Хуримтлагдсан ашиг (алдагдал) мянган төгрөг	Нийт мянган төгрөг
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,312,500.0	787,500.0	1,193,580.9	3,293,580.9
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа				
Залруулагдсан үлдэгдэл	1,312,500.0	787,500.0	1,193,580.9	3,293,580.9
Хувьцаат капиталын өсөлт (бууралт)				
Зарласан ногдол ашиг			(200,000.0)	(200,000.0)
Тайлант үеийн цэвэр ашиг			641,756.7	641,756.7
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,312,500.0	787,500.0	1,635,337.6	3,735,337.6
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа				
Залруулагдсан үлдэгдэл	1,312,500.0	787,500.0	1,635,337.6	3,735,337.6
Хувьцаат капиталын өсөлт (бууралт)	787,500.0			787,500.0
Зарласан ногдол ашиг			(320,000.0)	(320,000.0)
Нэмж төлөгдсөн капиталын өсөлт, (бууралт)		(787,500.0)		(787,500.0)
Тайлант үеийн цэвэр ашиг			342,045.9	342,045.9
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,100,000.0		1,657,383.5	3,757,383.5

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2018.12.31. мянган төгрөг	2017.12.31. мянган төгрөг
1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	4,115,091.5	5,052,689.7
Зээлийн хүүгийн орлого	1,812,649.5	1,411,685.9
Үнэт цаасны хүүгийн орлого	3,618.6	77,330.1
Харилцах дансны хүүгийн орлого	6,767.3	12,004.0
Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого	17.5	230.3
Гадаад валютын арилжааны орлого	1,542.0	
Үнэт цаасны арилжааны орлого	208,404.7	1,168,206.8
Гадаад валютын ханшийн зөрүү		2,892.9
Итгэлцлийн үйлчилгээний орлого	1,993,000.0	2,280,936.1
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	85,634.4	91,190.6
Бусад үйлчилгээний орлого	3,457.5	8,213.1
1.2 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	4,072,429.5	4,206,758.2
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	42,784.2	154,672.5
Төслийн зээлийн санхүүжилтийн хүүгийн зардал	6,303.3	18,195.0
Өрийн бичгийн хүүд төлсөн мөнгө	331,264.1	162,410.6
Үндсэн ба нэмэгдэл цалин	316,564.4	222,443.4
Ажилтнуудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	2,010.0	694.7
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд төлсөн мөнгө	67,084.0	49,154.3
Албан томилот, сургалтын зардал	13,590.8	17,049.4
Түрээс, менежментийн зардалд төлсөн мөнгө		70,468.7
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	20,922.4	12,018.1
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	5,323.0	4,840.4
Татвар, даатгалд төлсөн мөнгө	100,762.2	97,767.6
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	48,605.1	
Үнэт цаас болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбоотой гарсан мөнгө	310.7	29,125.2
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	30,405.5	6,500.7
Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан мөнгө	1,260,632.0	324,669.0
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	34,325.0	50,982.0
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	7,040.0	4,540.0
Ногдол ашгаар олгосон мөнгө	36,576.0	22,860.0
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	1,747,926.8	2,958,366.5
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	42,662.0	845,931.6

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2018.12.31. мянган төгрөг	2017.12.31. мянган төгрөг
2.ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1 Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	9,757.4	25,460.0
Үндсэн хөрөнгө ба өмчлөх бусад хөрөнгө борлуулсны орлого		25,460.0
Ногдол ашгийн орлого	6,299.9	
Хандив		
Бусад	3,457.5	
2.2 Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	23,964.8	9,296.4
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	21,636.1	7,674.6
Хандив		1,500.0
Торгуулийн зардал	2,328.7	121.8
Бусад		
Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(14,207.4)	16,163.6
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	28,454.6	862,095.2
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,095,274.2	233,179.0
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,123,728.8	1,095,274.2

Хүчтэй. Хамтдаа.